



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 07 сарын 01 өдөр


Дугаар Б/45

Бор-өндөр сум

**Б.Бат-Эрдэнийг Халдвартын эмчээр
хавсран ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 тогтоолын 7 дугаар хавсралт, Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журмын 4.4, Үйлдвэрчний эвлэлийн хорооны 2024 оны хамтын гэрээний 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Их эмч Б.Бат-Эрдэнийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Халдвартын эмчээр хавсран ажиллуулсугай.
2. Б.Бат-Эрдэнэд халдвартын эмчээр хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг цалингийн 30%, хэвийн бусын нэмэгдэл 10%-иар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (Б.Энхмаа)-д даалгасугай.

ДАРГА  А БАТБААТАР

